

“Бодлогын инноваци – 2020”-д шалгарсан 9 төслийг туршин нэвтрүүлэх ажил эхэллээ

Төрийн албаны зөвлөл, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжүүлж буй "Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төсөл хамтран нийт төрийн захиргааны албан хаагчдын дунд Бодлогын инновацийг туршин нэвтрүүлэх бичил төслийн сонгон шалгаруулалтыг 2020 оны 4 дүгээр сард зарласан билээ. Сонгон шалгаруулалтад нийт 37 төрийн байгууллагын 54 төслийн санал ирж, үүнээс 9 байгууллагын, 9 төсөл шалгарчээ. Эдгээр шалгарсан төслүүд ирэх наймдугаар сарыг дуустал хэрэгжиж, ирэх есдүгээр сард үр дүнгээ хэлэлцэх юм.

Шалгарсан төслүүдээс дурдвал, малчдын бүлгийг сайн дурын нийгмийн даатгалд хамрагдахад зан үйлийн сэтгэлгээ (Behavioral insights) хэрэглэх төсөл, иргэдийн санал, хүсэлтийг ил тод болгоход загварчлалын сэтгэлгээ (Design thinking) хэрэглэх төсөл зэрэг яам, агентлаг, орон нутгийн төлөөллийн байгууллагуудаас бүрдсэн 9 төсөл шалгарсан байна. Эдгээр төслүүд нь сонгон шалгаруулалтын удирдамжийн дагуу системийн сэтгэлгээ, загварчлалын сэтгэлгээ, зан үйлд нөлөөлөх чадвар зэрэг арга хэрэгслүүдийг ашиглан хэрэгжих юм.

Эдгээр шалгарсан 9 багийн гишүүд төслөө нарийвчлан хэлэлцэж, төлөвлөгөөгөө боловсруулсан хэлэлцэх сургалтыг хийх үеэр “Бодлогын инноваци - 2020” төслийн хэрэгжүүлэгч болон оролцогч талуудын заримаас дараах асуудлыг тодруулан ярилцлаа.

“Бодлогын инноваци - 2020” бичил төслийн зөвлөх З.Цолмонбаяр:

Төрийн албан хаагчид энэ үйл ажиллагааны дараа инновацийн аргуудыг эзэмшиж, туршиж үлдэх нь хамгийн том үр дүн.

-Төслийн шалгаруулалтад ирсэн нийт 54 төслийн санал төрийн захиргааны хэчнээн байгууллагаас, ямар үйл ажиллагаанд түлхүү чиглэсэн агуулгатай төслүүд байсан бэ?

- Ирсэн төслийн саналуудын ихэнх нь иргэдийн асуудлыг шийдэх тухайд байсан. Төрийн үйлчилгээг хэрхэн, яаж сайжруулж иргэдэд хүндрэл, чирэгдэлгүй хурдан хүргэх вэ гэдэг дээр асуудал нь төвлөрсөн төслийн саналууд ирсэн.
- Сонгогдсон 9 төсөл гэхэд малчдыг сайн дурын нийгмийн даатгалд хамруулахад чиглэсэн төсөл, Нийгмийн даатгалын үйлчилгээг хялбар шуурхай болгоход чиглэгдсэн төсөл байна. Санал, хүсэлтийг хялбаршуулахад чиглэсэн, байгууллагын соёлын дотоод процессыг сайжруулахад зорьсон, төрийн үйлчилгээний ил тод хариуцлагатай байдлыг сайжруулахад чиглэсэн, автозамын ачааллыг хэрхэн бууруулах вэ зэрэг төсөл байна.
- **Төрийн ямар байгууллагуудаас ирсэн 9 төсөл шалгарсан бэ?**
- 3 яам, 3 агентлаг, хөдөө орон нутгийн 3 төрийн байгууллагаас тус тус ирүүлсэн 9 төсөл шалгарсан. Үүнд, ХЗДХЯ, ХХААХҮЯ, ЗТЯ, Стандартчлал хэмжилзүйн газар, Гаалийн ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар гэсэн гурван агентлаг. Хөдөө орон нутгаас Говь-Алтай аймгийн ЗДТГ, Өвөрхангай аймгийн Гучин ус сумын ЗДТГ, Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс гэсэн гурван төлөөллийн байгууллагууд байна.
- **Төслийн сонгон шалгаруулалтад ямар байгууллагуудаас оролцсон бэ?**

- Төрийн албаны зөвлөл, ЗГХЭГ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Удирдлагын Академи мөн бие даасан Судалгааны байгууллагууд зэрэг байгууллагуудын төлөөллүүд багтсан.
- **Бичил төслийг сонгон шалгаруулахад ямар үзүүлэлтийг чухалчлан авч үзсэн бэ?**
- Төслийн сонгон шалгаруулалтын удирдамжид тусгасан шинэ арга хэрэгслүүдийг хэрхэн яаж хэрэглэсэн эсэхийг авч үзсэн. Төслийн багуудад эхлээд сургалтыг өгсөн. Дараа нь төсөлдөө тэдгээрийг хэрхэн яаж хэрэглэж, ашигласан байна вэ гэдгийг харсан. Дараа нь энэхүү төслөөр ямар асуудлыг шийдэх гэж байна вэ гэдэг асуудлыг харсан. Мөн хэнд зориулж шийдэх гэж байна вэ, хэр зэрэг ач холбогдолтой асуудал байна вэ зэрэг шалгууруудаар сонгосон. Шалгаруулахад их хэцүү өрсөлдөөн өндөр байсан.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДИЙН АВТО ЗОГСООЛЫН АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭСНЭЭР НИЙСЛЭЛИЙН ХУВЬД ХАМГИЙН ХЯЗГААРЛАГДМАЛ НӨӨЦИЙГ ЭРХ ТЭГШ АШИГЛАХ БОЛОМЖ НЭЭГДЭНЭ

- **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай тэмдэгт авто зогсоол төсөл-**

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газрын Тамгын газрын дарга Б.Хурцэцэг:

- **“Бодлогын инноваци - 2020” бичил төслийн сонгон шалгаруулалтын зарыг хаанаас харсан бэ, яагаад оролцох болов?**
- Төрийн албаны зөвлөлөөс “Бодлогын инноваци - 2020” бичил төслийг шалгаруулна гэдэг албан бичиг, хүсэлт манай байгууллага дээр ирсэн. Түүний дагуу удирдлагуудтайгаа зөвшилцөж, багаа бүрдүүлээд төслийн уралдаанд оролцохоор шийдсэн.
- **Ямар төслийн санал шалгарсан бэ?**
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд маш олон асуудлууд тулгамддаг. Тэдгээрээс хамгийн чухал асуудал нь юу гэдэг дээр бид нөхцөл байдлын үнэлгээг хийж, хоорондоо хэлэлцэж, ярилцаж байгаад зогсоолын асуудлыг нэн тэргүүнд шийдвэрлэх нь чухал гэж үзсэн. Зогсоолын асуудлыг шийдвэрлэснээр хөгжлийн бэрхшээлтэй иргэд төрийн үйлчилгээг авахад бас нэгэн том дэмжлэг болох юм. Энэ төслөөрөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зогсоолыг төлөвлөхөөр шийдсэн.
- **Та бүгдийн энэхүү шалгарсан төсөл хэчнээн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зогсоолыг хаана хийхээр төлөвлөгдөж байна вэ?**
- Энэ төсөл маань бичил төсөл тул Нийслэлийн хэмжээнд бүх зогсоолыг төлөвлөх боломжгүй. Гэвч бид туршилтын байдлаар эхний ээлжид өөрсдийн байгууллага дээр болон харьяа дүүргүүдийнхээ хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамгийн их үйлчилгээ авдаг дүүрэг, нэг цэгийн үйлчилгээг сонгож төслөө хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.
- **Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд зогсоолын асуудлаас үүдэлтэй ямар хүндрэл, бэрхшээл гардаг вэ?**
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийн асуудал гэж ярьдаг. Хүртээмжийн асуудал дотроо дэд бүтцийн, мэдээллийн хүртээмж гэж бий. Зогсоол нь дэд бүтцийн хүртээмжийн асуудалд орно. Үүнд, орц, гарц, налуу зам, лифт, зогсоол зэрэг асуудлууд нь багтдаг. Эдгээрээс бид зогсоолыг яагаад сонгох болсон гэхээр байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зогсоол байх ёстой гээд ямар ч хамаагүй тэмдэг, тэмдэглэгээ тавиад орхидог. Түүн дээр нь энгийн иргэд автомашинаа байрлуулах эсвэл стандарт шаардлагыг хангаагүйн улмаас

хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх боломжгүй болдог. Үүнтэй холбоотойгоор бид ТББ-уудтай хамтраад хүртээмжийн үнэлгээг хийсэн. Олон улсын стандарт бүхий зураглалаараа тэргэнцрийн зураг байдаг. Гэвч түүнийг зөвхөн тэргэнцэртэй хүний зогсоол гэж ойлгож болохгүй. Бүх л хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан гэдгийг анхаарах хэрэгтэй.

ТАЗ, ЗГХЭГ болон НҮБХХ-ийн төслийн хамтран хэрэгжүүлж буй энэхүү туршилтын үйл ажиллагааны талаар бид цувралаар сурвалжилж багуудын learning journey замаар хамтдаа аялах болно.